



94 Page



95 Page



96 Page

Moses1

-Moses1-

- Тайлбарлагч** Израиль хүмүүс, Египетэд амьдраад дөрвөн зуун жил болжээ. Энэ хугацаанд Израилийн хүн амын тоо ихээр өсчээ. Үүнд Египетийн хаан Фараоны санаа нь ихэд зовж эхлэв.
- Фараон** Израильчууд бид нараас олон болж байна. Хэзээ нэгэн цагт дайн болвол тэд бидэн рүү довтолж магадгүй.
- Тайлбарлагч** Тэгээд Фараон хаан Израиль хүмүүсийг боолоо болгон, тэднийг дарамталж байлаа.
- Египет хүн** “За хурдан хурдан, тоосго дахиад ихийг хий. Юундаа хөдөлж ядаад байгаа юм бэ? Ташуурдахаас нааш...!
- Эрэгтэй** яа яа!, ёо ёо!
- Эмэгтэй** “Бурхан минь, авраач! Биднийг зовоож байгаа Египетчүүдээс биднийг чөлөөлөөч.
- Тайлбарлагч** Египетийн боол болсон Израильчууд амрах ч завгүйгээр тэдний бүх ажлыг хийж байв. Египетчүүд тэднийг зовоож байсан ч Израильчууд Бурханы ивээлээр улам олон болж байлаа.
-
- Тайлбарлагч** Гэтэл нэгэн өдөр, Египетийн хаан Фараон эх баригчдыг ордондоо дуудав.
- Фараон** Израилийн эмэгтэйчүүдийг амаржихад нь охин гарвал амьд үлдээж, хүү төрвөл Нил гол уруу шидэж устга!
- Тайлбарлагч** Эх баригчид Бурханаас илүү их айсан учир шинээр мэндэлсэн хүү бүрийг амьд үлдээв. Бурхан тэр эх баригчдыг ерөөжээ. Фараон хаан Израильчуудыг өөрийнхөө мөнхийн зарц болгох бодолтой байжээ. Харин Бурхан Израильчуудын залбирлыг сонсож, тэднийг аврахаар төлөвлөжээ.
-
- Тайлбарлагч** Нэгэн Израиль эмэгтэй хүү төрүүлжээ. Эх баригч нь хүүг харахад маш царайлаг, хайр хүрэм байсан тул хүүг гол руу шидэж чадсангүй. Түүний гэр бүл гурван сарын турш хүүг нууцаар өсгөжээ. Хүү өсөх тусам уйлах дуу нь чангарч байсан тул цаашид нуун өсгөх боломжгүй болжээ.
- Ээж** Бурхан минь миний хүүг хамгаалаарай
- Тайлбарлагч** Хүүгийн ээж Бурханд хандан уйлан залбирчээ. Эцэст нь эмэгтэй зэгсэн сагс авч түүнийг барагшин болон давирхайгаар шавж ус нэвтрэхгүй болгоод хүүгээ дотор нь хийлээ. Тэгээд түүнийгээ Нил мөрний эрэг дагуу зэгсэн дунд тавьжээ



97 Page

- Тайлбарлагч** Хүүгийн эгч Мириам зэгсэн дундаас дүүгээ ажиглан харж байв. Гэтэл Фараоны гүнж усанд орохоор ирж гэнэ. Харин өнөөх зэгсэн сагс гүнжийн ойролцоо ирээд тогтчихов. Удалгүй гүнж тэр сагсыг олж хараад:
- Гүнж** Тэр сагсыг надад авчрагтун. Юу болох нь энэ вэ! Израиль хүү байх чинь ! Одоо яах вэ?
- Тайлбарлагч** Тэр үед бүхнийг нуугдан харж байсан Мириам гүнж рүү гүйн очлоо.
- Мириам** Гүнжтэн минь, хүүг асрах хүнийг би танд олж өгөх үү ?
- Гүнж** Тэгвэл сайн байна.
- Тайлбарлагч** Мириам баярлан гүйсээр гэртээ ирлээ.
- Мириам** Ээжээ! Фараоны гүнж дүүг олчихлоо. Дүүг асрах хүнийг хайж байгаа тул та хурдан тийшээ яваарай.
- Ээж** Юу? Нээрээ юу? Бурхан минь танд маш их баярлалаа.
- Тайлбарлагч** Хүүгийн эх хамаг хурдаараа гүйсээр гүнж дээр ирэв. Тэгээд хүүг мэдэхгүй мэт царйлжээ.
- Гүнж** Энэ хүүг хөхүүлэн асарч өг.
- Эх** За, гүнжтээн.
- Тайлбарлагч** Ийнхүү Бурхан бяцхан хүүд ээжтэйгээ хамт өсөх боломжийг өгчээ.



98 Page

- Тайлбарлагч** Фараоны гүнж хүүг Мосе гэж нэрлэжээ. Мосе гэдэг нэр нь “уснаас гаргаж авсан” гэсэн утгатай байлаа. Мосе өсөж том болжээ. Нэгэн өдөр хүүгийн эх түүнд бүх үнэнийг хэлж өгчээ.
- Эх** Чи гүнжийн хүү боловч Израиль хүн. Ордонд өссөн ч, зовлон дунд байгаа Израильчуудыг битгий мартаарай.
- Тайлбарлагч** Тэгээд Мосед Бурханы тухай ярьж, Бурханд итгүүлэв. Мосе гүнжийн хүү болж, бусад ханхүү нарын адилаар ордонд олон зүйлийг сурч байлаа. Тэгээд ухаалаг, чийрэг сайхан залуу болж өсчээ.



99 Page

- Тайлбарлагч** олон жилийн дараа Бурхан Мосег Израилчуудыг чөлөөлөх мундаг удирдагчаар бэлдсэн юм. Мосе Бурханы хэлсний дагуу өөрийн ард түмнийг Египетээс удирдан гарчээ.
- Боолууд** “Одоо бид эрх чөлөөтэй! Бид нар энэ цагаас эхлэн боолчууд биш болсон!
- Тайлбарлагч** Хүмүүс маш ихээр баярлан Мосегийн араас баяртайгаар алхаж байлаа. Бурхан зовлонд дунд байсан Израильчуудыг ингэж аварсан юм. Одоо Израильчууд Бурханд хүндэтгэл өргөж чадах эрх чөлөөтэй хүмүүс болжээ.